



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Даланзадгад хот
2016 он

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

Агуулга

Тайланг бэлтгэсэн: Байгууллагын дарга, Тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр Аудитын менежер Д.Алдармөнх Ахлах аудитор Т.Хонгорзул Аудитор Г.Цэрэнлхам Д.Сүрэнжаргал Шинжээч Ш. Отгонбаяр Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 303 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт Бүлэг 1 Байгаль орчныг хамгаалах эрх бүхий төрийн байгууллагууд хуульд заасан үүргээ биелүүлж ажилласан байна Бүлэг 2 Усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна. Бүлэг 3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд заасан дагуу мөрдөөгүй байна. Бүлэг 4 Ус рашааны нөөц ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна. Дүгнэлт Зөвлөмж Албан шаардлага Хавсралтууд Судалгаа 1 Судалгаа 2
--	--



Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани

АУДИТЫГ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН ЗОРИЛТ

Байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймгийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээллэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Байгаль орчны газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль, тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх;
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад Байгаль орчны газар, аймаг, сумдын ИТХ, бүх шатны Засаг дарга түүний харьяа байгууллагууд, Татварын газар, холбогдох аж ахуй нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан гүйцэтгэв.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Аудитыг Тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр удирдаж, үе шатны болон чанарын стандартыг аудитын менежер Д.Алдармөнх хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хонгорзул, аудитор Д.Сүрэнжаргал, Г.Цэрэнлхам, шинжээч Ш.Отгонбаяр нар хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Байгаль орчныг хамгаалах эрх
бүхий төрийн байгууллагууд
хуульд заасан үүргээ биелүүлж
ажилласан байна

1.1 Байгаль орчин аялал жуулчлалын газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газар /цаашид БОАЖГ/ 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, Аймгийн засаг даргаар батлуулсан байна. Дараах 9 зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөжээ. Үүнд:

- Байгаль орчин ногоон хөгжлийн бодлогын менежментийг хэрэгжүүлэх
- Байгаль орчныг хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллагын ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх
- Агаарын бохирдол, хог хаягдлын менежментийг сайжруулах
- Биологийн олон янз байдлын нөөцийг тогтоох, хамгаалах
- Ойжуулалт болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- Усны ашиглалт, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тулгуурлан газар, газрын хэвлийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулах
- Хяналт шалгалтыг сайжруулах
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын хүрээнд доорхи ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Агаарын бохирдол, хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд орчныг ногооруулах, хог хаягдлыг цэвэрлэж хөрсний бохирдлыг багасгах үүднээс бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж 271232 мод, бүх нийтийн цэвэрлэгээг аймгийн хэмжээнд 19 цэгт 1313,3 га газрыг хамруулан цэвэрлэсэн байна.

Биологийн олон янз байдлын нөөцийг тогтоох, хамгаалах зорилгоор амьтныг хууль бусаар агнахаас урьдчилан сэргийлж хууль хяналтын байгууллагуудтай хамтран 20 гаруй удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулжээ.

Ойжуулалт болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинээр байгуулах эхлэлийг тавьж Даланзадгад суманд жишиг ногоон байгууламжийг 13 га-д шинээр байгуулсан байна.

Усны ашиглалт, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын ИТХ-ын тогтоолоор төвийн усан хангамжийн худгуудад эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоолгож, тэмдэгжүүлсэн

байна. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3¹-д заасны дагуу уст цэгийн тооллогын ажлыг Аймгийн Засаг даргын А/244 дугаар захирамжаар 4 сав газрын захиргаа сумдын удирдлагууд, иргэдтэй хамтран зохион байгуулсан байна. Тооллогоор 5775 уст цэг тоологдсноос 556 булаг, 842 гүн өрмийн худаг, 4049 энгийн уурхайн худаг, 328 бетонон хашлагат худаг тоологджээ.

Хяналт шалгалтыг сайжруулах ажлаар Аймгийн Засаг даргын А/83 дугаар захирамжаар Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн эзэмшил газрын ашиглалт, хамгаалалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түгээмэл тархацтай ашигт малтмал болон ус ашиглах дүгнэлт, гэрээ, төлбөр ногдуулалт, төлөлтийг шалгах зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг авч хэрэгжүүлсэн байна.

Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 2015 оны жилийн эцэст 89,4 хувьтай дүгнүүлсэн байна.

1.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсөв баталсан боловч хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1²-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид АИТХ/ 2015 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 4562,7 сая төгрөг зарцуулахаар 2015 оны 9/4 дугаар тогтоолоор баталсан байна.

*Байгаль хамгаалах чиглэлээр 2015 онд хийгдэх хөрөнгө
оруулалтын жагсаалт*

Хүснэгт 1.

/мянган төгрөг/

Д/д	Зорилт, арга хэмжээнүүд	хэрэгжүүлэх хугацаа		2015 онд санхүүжих дүн /тодотго л/
		эхлэх	дуусах	
1	Байгаль хамгаалагч нарыг тоног төхөөрөмж хангах	2015	2015	18 000,0
2	Мод тарьж ургуулсан иргэн аж ахуй нэгж байгууллагад урамшуулал олгох журмын дагуу 2013, 2014 онд тарьсан болон шинээр мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгжид урамшуулал олгох	2015	2015	30 000,0
3	Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд булгийн эхийг хашиж, хамгаалах ажлыг үргэлжлүүлэх	2015	2015	140 000,0

¹ Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд тухайн шатны засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын хэмжээний усны мэдээллийн санд оруулна

² Аймаг нийслэлийн ИТХ байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

4	Сумдын ус ашиглагч нарт хяналт тавьж тоолуургүйгээр ус ашиглах зөрчлийг арилган хяналт шалгалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулж ус хэрэглэгч, ашиглагчдыг тоолууржуулж усны тоо бүртгэлийг зохион байгуулах	2015	2015	20 000,0
5	Сумдын хүн амын ундны ус хангамжийг сайжруулах хүрээнд худагт ус цэвэршүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	2015	2015	20 000,0
6	Даланзадгад сумын төвлөрсөн унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуй бүс 50 метрээр хашаажуулалт, хамгаалалт хийж хамгаалалт бүр /200/ метрээр тэмдэгжүүлж дэглэмийг мөрдүүлж ажиллах	2015	2015	95 000,0
7	Сав газрын байгаль хамгаалах ажлын хүрээнд байгаль хамгаалах нөхөрлөл, клубүүдийн үйл ажиллагааг урамшуулах, хамтран ажиллах, сургалт сурталчилгааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	2015	2015	20 000,0
8	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хөгжлийг дэмжих, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нөхөн сэргээх, тэмдэгжүүлэх	2015	2015	20 000,0
9	Усны сав газруудад зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал,ургамал ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг сайжруулж ажиллах	2015	2015	40 000,0
10	Сав газрын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд аймгийн Ойн менежментийн 2015 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх /мод үржүүлгийн газар 5 га, ойжуулалт, зүлэгжүүлэлт, сургалт, цөлжилтийн зэрэглэл тогтоох/	2015	2015	220 000,0
11	Сав газрын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд УТХГ нутгийн тодорхой хэсэгт экологи эдийн засгийн үнэлгээг тогтоолгох	2015	2015	80 000,0
12	Сав газрын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах 2015 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх Даланзадгад сумын хог хаягдлын цэгт ажлын байр, хог ангилан ялгах, хог хаягдлын тоо бүртгэл хийх	2015	2015	100 000,0
13	Номгон сумын цэвэр усны сүлжээг үргэлжлүүлэх барих	2015	2015	125 200,0
14	Даланзадгад сумын Соёл амралтын хүрээлэнгийн цэвэрлэх байгууламж, ногоон байгууламж	2015	2015	290 000,0
15	Үерийн далангийн нэмэлт суваг шуудууны ажил	2015	2015	330 000,0
16	Д3 сум цэвэр бохир усны шугам сүлжээний зураг төсөв	2015	2015	82 000,0
17	Даланзадгад сумын гэр хорооллын зарим хэсгийн цэвэр бохир усны шугамд холбох ажлыг үргэлжлүүлэх	2015	2015	2 513 460,0
18	Даланзадгад сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлын үлдэгдэл	2014	2015	419 000,0
ДҮН				4 562 660,0

АИТХурал Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1³ -д заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүнийг баялгийн зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд батлагдсан төсвийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

1.3 Засаг дарга байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

³ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын байгаль орчныг хамгаалах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, түүний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэн эрхийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2⁴-т тусгаж өгсөн байна.

Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2⁵-д заасны дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтад 4562,7 сая төгрөг зарцуулахаар АИТХ-д өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж ажилласан байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд /цаашид БОНХАЖС/ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 16.2, Усны тухай хуулийн 7, 12, 24, 28, 29 дүгээр зүйл, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1⁶ дэхь заалтыг тус тус үндэслэн Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

Гэрээний хавсралтад орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 23 төсөл арга хэмжээнд 1918,5 сая төгрөг, дотоод нөөц бололцоо болон хувийн хэвшил, гадаад дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 9 арга хэмжээг тусгасан байна.

Гэрээний хэрэгжилтийг 2015 оны жилийн эцэст БОНХАЖСайд дараах байдлаар тооцсон байна.

*Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдтай
байгуулсан гэрээний хэрэгжилт*

Хүснэгт 2.

Д/Д	ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ
1	Говь гурвансайхан Байгалийн цогцолборт газрын экологи эдийн засгийн үнэлгээг тогтоох	100
2	Байгаль хамгаалагч нарыг тоног төхөөрөмжөөр хангах	100
3	Өмнөговь аймгийн цөлжилтийн төлөв байдал, зэрэглэлийг тогтоох	40
4	Герман улсад зохион байгуулагдах аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас төлөөлөл оролцуулан туршлага судлахад дэмжлэг үзүүлэх	100
5	Элсэн урлал олон улсын уралдаан "Алтан шаргал элс" эвент арга хэмжээ санаачлан зохион байгуулах	30
6	Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай хамтран усны тоо бүртгэлийг зохион байгуулах	100
7	Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	100

⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх дараах бүрэн эрхийг эдэлнэ.

⁵ Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлэх гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулна

⁶ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

8	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нөхөн сэргээлт, аудитын эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх болон бусад чиглэлийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	100
9	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хөгжлийг дэмжих, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, нөхөн сэргээх, сургалт сурталчилгаа хийх	100
10	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт тэмдэгжүүлэлт хийх	100
11	Улсын тусгай хамгаалалттай газарт хууль бусаар олборлолтонд өртсөн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	100
12	Улсын тусгай хамгаалалттай газарт биотехникийн арга хэмжээг дэмжих	100
13	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт ойжуулалт хийх	0
14	Мод үржүүлгийн газар байгуулах	100
15	Ойн нөхөрлөлийг дэмжих	100
16	Даланзадгад сумын төвлөрсөн унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуй бүс 50 метрээр хашаажуулалт, хамгаалалт хийж хамгаалалт бүр /200/ метрээр тэмдэгжүүлж дэглэмийг мөрдүүлж ажиллах	100
17	Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэх	100
18	Тээвэр оношлогооны төв дээр аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах	100
19	Альша, Баяннуур аймгуудын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, хамтын ажиллагааны гэрээ байгуулах	100
20	Сумдын хүн амын ундны ус хангамжийг сайжруулах хүрээнд зарим сумдын худагт ус цэвэршүүлэх, цэнгэгжүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах	80
21	Даланзадгад сумын хог хаягдлын цэгт дахин боловсруулах бага оврын үйлдвэрийн барилгыг барьж байгуулах	100
22	Ус цаг уур, орчны шинжилгээний албаны конторын барилга барих	0
23	Гашуун сухайт, Шивээхүрэнгийн боомтын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж нөөцийг тогтоох,	0
ДҮН		80,4

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг 80,4 хувьтай тооцож, БОАЖЯ-нд хүргүүлсэн боловч хувийн хэвшил, гадаад дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс 70,9 хувиар “С” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Аудитын явцад Гурвантэс сумын нутагт ашигт малтмалын хайгуулын ХҮ-019866 тусгай зөвшөөрөл эзэмшигч “Баатарван транс” ХХК үйл ажиллагаа явуулахдаа Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1⁷, 26 дугаар зүйлийн 26.1⁸, 31 дугаар зүйлийн 31.1⁹, “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” батлах тухай БОАЖС 2013 оны А-156 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

⁷ Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.

⁸ Иргэн, аж ахуй нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна.

⁹ Ус ашиглах, зөвшөөрөл, гэрээнд заасан заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх

Мөн дараах хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Үүнд:

- 2016 онд гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан суваг нэвтрэлтийн ажлыг хийхдээ төлөвлөгөөний дагуу хийгээгүй, илүү хэмжээгээр газар ухаж эвдсэн нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.2¹⁰ дэх заалт,
- Хайгуулын ажлын явцад технологийн туршилт хийж, дээж авах зорилгоор 20 тонн улаан хас чулууг олборлож экспортонд гаргахаар төлөвлөж МХЕГазраас зөвшөөрөл авсан байна. Гэвч олборлосон ашигт малтмалын бүртгэл хөтлөөгүй, дээжийн хэмжээ тодорхойгүй байсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11¹¹ дэх заалт,
- Хайгуулын ажил явуулах хугацаандаа суваг малталтын ажлын хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан иргэнээр гүйцэтгүүлсэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт,
- Хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл тоо хэмжээг хайгуулын ажил хийгдэж дууссаны дараа МХГ-т бүртгүүлж, худалдан борлуулах зөвшөөрөл аваагүй нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9-дэх заалт,
- Хайгуулын талбай байрших түр кемп, авто зогсоолын орчинд ил задгай хог хаягдал гарсан, төвлөрсөн цэг байгуулаагүй нь Хог хаягдын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6, 9.2.4, 9.2.5, 9.2.6, 9.2.9, 9.3-р заалтуудыг тус тус зөрчиж байна.

Бүлэг 2

Усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.1 Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн усны нөөц ашиглалтыг тооцохгүй орлогыг төлөвлөж, ус ашиглах дүгнэлтийг үндэслэлгүй гаргаж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг “2015 оны орон нутгийн төсөв батлах тухай” АИТХ-ын 2014 оны 6/4 дугаар тогтоолоор 19900,0 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

¹⁰ Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалтта холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх

¹¹ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улирал бүр тухай улиралд олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээг тооцсон үндэслэл болон төлбөрийн нийт хэмжээг тусгасан тайланг мэргэжлийн хяналтын албанаас баталсан маягтын дагуу үнэн зөв гаргаж, баталгаажуулан тус албанд ирүүлнэ.

2015 оны төсвийн тодотгол батлах тухай АИТХ-ын 2015 оны 9/4 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 13900,0 сая төгрөгөөр тодотгон, 6000,0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4¹²-д заасны дагуу “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газар /цаашид ТӨҮГ/-ын гаргасан ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Галба-Өөш, Долоодын говийн сав газар, Алтайн Өвөр говь сав газрын захиргаатай байгуулсан гэрээнээс үзэхэд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 22,4 сая м3 усны нөөц ашигласны төлбөрөөс 20817,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр байна.

Гэрээгээр 2015 онд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрийн орлогын тооцоолол

Хүснэгт 3.

/мянган төгрөгөөр/

№	Аж ахуйн нэгжийн нэр	Ашиглах ус м3 /гэрээгээр/	Усны нөөц ашигласны төлбөрийн орлого /гэрээгээр/
1	Эрдэнэс тавантолгой ХХК	143 610	136 476,9
2	Энержи ресурс ХХК	1 692 000	1 622 695,7
3	Оюу толгой ХХК	17 958 000	17 222 440,3
4	Таван толгой ХК	1 486 810	1 069 426,2
5	Соусгоби сэндс ХХК	455 000	363 062,7
6	Чинхуа Мак Нарийн сухайт ХХК	178 704	142 595,1
7	Өсөх зоос ХХК	108 712	86 745,3
8	Монголын алт МАК ХХК	235 365	44 525,5
9	Цагаан өвөлжөө ХХК	162 425	129 605,4
Дүн		22 420 625	20 817 573,1

Аудитын явцад объект дээр ажиллахад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5¹³-д заасан үйлдвэрлэлийн хүчин чадал, техник эдийн засгийн үзүүлэлтийг үндэслэхгүй ус ашиглах дүгнэлтийг гаргасан зөрчил илэрлээ. Үүнд:

- БОАЖГазар “Жавхлант орд” ХХК-ийн 2015 оны 15/045 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг гаргахдаа хайгуулын ажлын төлөвлөгөөгөөр 15000 тууш метр өрөмдөхөөр төлөвлөснийг 5000 тууш метр болгон 10000 тууш метрээр буюу усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,2 сая төгрөгөөр бууруулж гаргасан байна.

¹² Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоо метр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоо метр хүртлэх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

¹³ Үйлдвэрлэлийн хүчин чадал техник эдийн засгийн үзүүлэлт

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

Ус ашиглуулах гэрээг үндэслэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг төлөвлөхгүй, өмнөх болон тухайн оны гүйцэтгэлд тулгуурлан тодотгон баталж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.9-¹⁴д заасны дагуу Унд ахуйн зориулалтаар Баян-Овоо сум 3,3 сая, Ноён сум 1,0 сая нийт 4,3 сая төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 29,3 сая төгрөг төвлөрсөн байна.

2015 оны унд ахуйн зориулалтаар ашигласан усны
орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 4.

/мянган төгрөгөөр/

№	СУМЫН НЭР	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	БИЕЛЭЛТ
1	Баяндалай			-
2	Баян-Овоо	3 300,0	3 411,4	111,4
3	Булган		1 378,8	1 378,8
4	Гурвантэс		2 169,8	2 169,8
5	Мандал-Овоо		2 796,6	2 796,6
6	Манлай			-
7	Номгон		705,2	705,2
8	Ноён	1 000,0	7 636,2	6 636,2
9	Сэврэй			-
10	Ханбогд		3 525,1	3 525,1
11	Ханхонгор		65,4	65,4
12	Хүрмэн		59,3	59,3
13	Цогт-Овоо			-
14	Цогтцэций		7 590,4	7 590,4
15	Даланзадгад			-
ДҮН		4 300,0	29 338,2	25 038,2

Сумдууд өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бусад ашиг олох зориулалтаар ахуй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс усны нөөц ашиглах төлбөрийн орлогыг төлөвлөөгүй байна.

2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.

2015 онд үйлдвэрлэл, үйлчилгээний усны төлбөрийн орлогоос 13636,8 сая төгрөг төвлөрч, 263,2 сая төгрөг буюу 1,8 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан байна. /судалгаа №1 хавсралтад/

Унд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 29,3 сая төгрөг сумдын орон нутгийн төсөвт төвлөрсөн байна.

¹⁴ Хүн амын унд ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр

Аудитаар ус ашиглагч аж ахуй нэгж компаниуд Усны тухай хуулийн 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1¹⁵ дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Монголын алт МАК” ХХК 5-р худгийн усыг унд ахуйн зориулалтаар бус тоног төхөрөмжийн угаалга цэвэрлэгээнд үйлдвэрлэлийн чиглэлээр зориулалт бусаар ашигласан,
- Мөн шүүрлийн усыг зүмбэний аргаар хуримтлуулж усны машинаар зөөж шавхан зайлуулалтыг хийхдээ баталгаажуулсан тоолуурыг суурилуулаагүй,
- Оюу толгой” ХХК унд ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээг дүгнэлтэд зааснаас 2014 онд 193139 м³, 2015 онд 72004 м³ усаар хэтрүүлэн ашигласан,
- “Өсөх зоос” ХХК “Монгол-Ус” ТӨҮГ-ын 2015 оны 15/01 дугаар ус ашиглах дүгнэлтийг үндэслэн Алтайн өвөр говийн сав газрын захиргаагаар шүүрлийн усанд 86,7 сая, унд ахуйн усанд 0,8 сая нийт 87,5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр гэрээ байгуулж, 78,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн 8,9 сая төгрөгийг төлөөгүй,
- “Жавхлант Орд” ХХК, “Монгол-Ус” ТӨҮГ-ын гаргасан 2015 оны 108 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулаагүй нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11¹⁶ дэхь заалтыг зөрчиж, ус ашиглах зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж, усны нөөц ашигласны төлбөрийн орлого 19,4 сая төгрөгийг төлөөгүй,
- “Мөнхноён Суварга” ХХК 2015 онд ус ашиглуулах дүгнэлтгүй, гэрээ байгуулаагүй зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан,
- “Энержи Ресурс” ХХК Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор батлагдсан усны нөөц ашигласны хувь хэмжээг зөрчин 5,3 сая төгрөгийг төлөөгүй байна.

“Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” батлах тухай БОАЖС-ын 2013 оны А-156 дугаар тушаалын 2.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Саусгоби сэндс” ХХК шүүрлийн усыг зүмбэний аргаар хуримтлуулж усны машинаар зөөж шавхан зайлуулалтыг хийхэд баталгаажуулсан тоолуурыг суурилуулаагүй, усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй,
- “Энериж Ресурс” ХХК “Монгол-Ус” ТӨҮГ-ын 2015 оны 72 дугаартай ус ашиглуулах дүгнэлтэд заасан уурхайн ухалгаас шавхан зайлуулах усанд баталгаажуулсан тоолуур суурилуулаагүй, усны нөөц ашигласны төлбөрийн орлого 79,9 сая төгрөгийг төвлөрүүлээгүй,
- “Монголын алт МАК” ХХК унд ахуйн хэрэглээний 5-р цооног тоолуурын хоорондох гол шугамаас салбарлаж усны крант гаргасан, 1 болон 2

¹⁵ Ус ашиглагч иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь ус, рашаан нөөц ашигласны төлбөр төлнө.

¹⁶ Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

дугаар худгаас ус цуглуулах гол шугам дээр баталгаажуулсан тоолуур суурилуулаагүй байна.

Иймд дээрхи хуулийн заалтуудыг хэрэгжүүлж, зөрчил арилгуулах албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18¹⁷ дахь заалтыг зөрчиж ус ашиглуулах дүгнэлтгүй 2014 онд 25 иргэн аж ахуй нэгж 11,9 сая, 2015 онд 24 иргэн аж ахуй нэгж 45,6 сая нийт 57,5 сая төгрөгийг аймаг, сумдын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. /нэрсийг хавсралт №2/

Ус ашиглуулах дүгнэлтгүй, гэрээ байгуулаагүй, үйл ажиллагаа явуулсан зөрчлийн цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг БОАЖГ-ын даргад хүргүүллээ.

Бүлэг 3

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд заасан дагуу мөрдөөгүй байна.

3.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд заасны дагуу мөрдөөгүй байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18 дугаар зүйлд заасан ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаар 35 хувь гэж заасан байдаг.

2015 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 4562,7 сая төгрөг зарцуулахаар баталсан нь төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаар 35 хувьд хүрэхгүй, 220,2 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна.

Байгаль хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт

Хүснэгт №2

/сая.төгрөгөөр/

Байгалийн нөөцийн төрөл	2015 онд төвлөрүүлсэн орлого	Тооцох хувь хэмжээ /35 хувь/	Батлагдсан төсөв	Дутуу тооцсон
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	13665,7	4782.9	4562.7	-220.2

¹⁷ Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.

3.3 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогоос 2015 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх 18 төсөл арга хэмжээнд 4562,7 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 16 төсөл арга хэмжээнд 1766,8 сая төгрөг зарцуулсан байна.

Дээрхи арга хэмжээнээс 18,0 сая төгрөгийн өртөгтэй байгаль хамгаалагч нарыг тоног төхөөрөмжөөр хангах, 2513,4 сая төгрөгийн өртөгтэй Даланзадгад сумын гэр хорооллын зарим хэсгийг цэвэр бохир усны шугамд холбох ажлууд зарцуулалтын эрх тавигдаагүй шалтгаанаар тухайн онд санхүүжилтийг шилжүүлээгүй байна.

Батлагдсан хөрөнгө оруулалтыг *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах”* журам батлах тухай Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийхэд 17,6 сая төгрөг,
- Унд ахуйн ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнэгжүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авахад 27,1 сая төгрөг,
- Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийхэд 218,1 сая төгрөг,
- Усны сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд 51,4 сая төгрөг,
- Усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас борооны усыг хуримтлуулах, цөөрөм байгуулах, булаг шанд, баянбүрдийг хамгаалах арга хэмжээнд 1,033,8 сая төгрөг байна.

3.5 Усны нөөц ашигласны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг журмын дагуу шийдвэрлэсэн байна.

“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх” тухай Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу унд ахуйн зориулалтаар усны эрдэсжилт, хатуулгыг цэнгэгжүүлж зөөлрүүлэн ашигласан 6 аж ахуй нэгж байгууллага 32,4 сая төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн байна. Үүнд:

2015 оны хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн аж ахуй нэгжүүд

Хүснэгт № 3

/ сая төгрөгөөр/

№	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлбөрөөс чөлөөлсөн усны хэмжээ, м3/жил	1м3 усны үнэ	Дүн
1	Эрдэнэс таван толгой ХХК	Нүүрс олборлох	16,350	95.90	1,5
2	Энержи ресурс ХХК	Нүүрс олборлох	3,365	95.90	0,3
3	Оюу толгой ХХК	Хүдэр олборлох, баяжуулах	290,272	95.90	27,9
4	Таван Толгой ХК	Нүүрс олборлох	8,357	95.90	0,8
5	Чинхуа мак ХХК	уул уурхай	7140.2	99.74	0,7
6	Монголын алт Мак ХХК	уул уурхай	12478	99.74	1,2
Дүн			337,962		32,4

Бүлэг 4

Ус рашааны нөөц ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна.

4.1 Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлж байна.

2015 оны 1-р улиралд “Саусгоби Сэндс” ХХК,” Чинхуа мак-Нарийн сухайт” ХХК, “Цагаан өвөлжөө” ХХК-иудад , 3-р улиралд “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХХК, “Таван толгой” ХК-иудад дэд бүтэц, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, байгаль орчин, геологи, уул уурхайн чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан ч Усны тухай хуулийн хэрэгжилт, ус рашааны нөөц ашиглалтанд хийсэн хяналтын тайлан байхгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2015 оны жилийн эцэст “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хяналт шалгалт хийсэн боловч ажлын тайланг БОАЖГ-аас ирүүлээгүй болно.

Аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан БОАЖГ-ын мэргэжилтэнд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1¹⁸ дэхь заалтыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлээ.

¹⁸ Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлс хийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Байгаль орчин аялал жуулчлалын газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна.
- АИТХурал байгаль орчныг хамгаалах, баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд баталсан төсвийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
- Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтийг тооцож ажиллажээ.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд заасны дагуу мөрдөөгүй байна.
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн усны нөөц ашиглалтыг төлөвлөхгүй, ус ашиглах дүгнэлтийг үндэслэлгүй гаргаж байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.
- Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн ч түүнд тавих хяналт хангалтгүй байна.

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР

нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал дүгнэл авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг Төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

АЛБАН ШААРДЛАГА

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд шаардаж байна. Үүнд:

Гурвантэс сумын Засаг дарга Г.Гангамаад:

- Усны нөөц ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын 723,384,096.00 төгрөгийн усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт нөхөн төлүүлэх
- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.4 заалтуудыг зөрчиж буй “Монголын Алт МАК” ХХК, “Чинхуа-Мак-Нарийн сухайт” ХХК-иудад Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.10–т заасны дагуу арга хэмжээ авах
- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18 дахь заалтыг зөрчсөн “Жавхлант-Орд” ХХК-д Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.9–д заасны дагуу арга хэмжээ авах

Баян-Овоо сумын Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Б.Эрдэнэцэцэгт:

- Усны нөөц ашигласны төлбөрийн дутуу төвлөрүүлсэн орлого 20,483,049.00 төгрөгийг орон нутгийн төсөвт нөхөн төлүүлэх

Цогтцэций сумын Засаг дарга С.Содбаатарт:

- “Энержи Ресурс” ХХК, “Ухаа худаг ус хангамж” ХХК-иудын усны нөөц ашигласны төлбөрийн дутуу төвлөрүүлсэн 205,093,565.00 төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт нөхөн төлүүлэх
- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэхь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-153 тоот тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг мөрдүүлэх ажил зохион байгуулах

Ханбогд сумын Засаг дарга Т.Буян-өлзийд:

- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-д заасныг зөрчиж, “Оюу толгой” ХХК унд ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээг дүгнэлтэд заасан хэмжээнээс 2014 онд 193139 м3, 2015 онд 72004 м3 усаар хэтрүүлэн ашигласан зөрчилд арга хэмжээ авах

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

БОАЖГазрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Пүрэвтулгад:

- Ус ашиглуулах дүгнэлтгүй, гэрээ байгуулаагүй иргэн хуулийн этгээд үйл ажиллагаа явуулсан зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөмж байна.